

ТАНИЛЦУУЛГА

“Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээ”-ний төслийн тухай

Монгол Улсын гадаад харилцаа өргөжин хөгжихийн хирээр иргэдийн гадаадад суралцах, ажиллах болон бизнес, аялалын чиглэлээр харилцан зорчих явдал нэмэгдэж байгааг харгалзан монголчууд ихээр зорчиж, амьдарч ажил хөдөлмөр эрхэлдэг улс орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээ, хэлэлцээр байгуулах асуудалд тус яамнаас анхаарал хандуулан ажиллаж байна.

Манай улс 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх асуудлаар гадаадын 22 улс оронтой нийт 40 гэрээ, хэлэлцээр байгуулсан байна. Үүнээс гэмт этгээд шилжүүлэх асуудлаар 16 улс (*Унгар, Болгар, Румын, Чех, Словак, Польш, Орос, Украин, Беларусь, Казахстан, Турк, Ардчилсан Солонгос, Өмнөд Солонгос, Вьетнам, Энэтхэг, Хятад*)-тай гэрээ, хэлэлцээр байгуулсан.

Бүгд Найрамдах Киргиз Улстай “Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын хооронд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай гэрээ”-г 1999 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Бишкек хотноо байгуулсан ба уг гэрээнд гэмт этгээд шилжүүлэхтэй холбогдох харилцааг ерөнхий байдлаар зохицуулсан байсан.

Дээрх харилцааг илүү тодорхой, нарийвчлан зохицуулах тухай саналыг анх Киргизийн талаас гаргаж, “Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээ”-ний төслийг ирүүлсэн бөгөөд манай талаас өөрийн саналыг хүргүүлж хамтран ажилласнаар Талууд гэрээний төслийг эцэслэн тохироод байна.

Энэхүү гэрээний төсөл нь 25 зүйлтэй бөгөөд харилцах эрх бүхий төв байгууллага, шилжүүлэн өгөх гэмт хэрэг, шилжүүлэн өгөх хүсэлтэд тавигдах шаардлага, холбогдох баримт бичиг, шилжүүлэн өгөхгүй байх үндэслэл, шилжүүлэн өгөх шийдвэр, шилжүүлэн өгч буй этгээдийг хүлээлгэн өгөх, шилжүүлэн өгөх хүсэлтийг хойшлуулах, түр хугацаанд шилжүүлэн өгөх, мөн эрэн сурвалжлагдаж буй этгээдийг урьдчилан баривчлах, шилжүүлэн өгөх хэд хэдэн хүсэлтийг шийдвэрлэх, гуравдагч улсад шилжүүлэн өгөх, эд зүйл, эд хөрөнгө шилжүүлэн өгөх, дамжин өнгөрөх, зардал зэрэг гэмт этгээд шилжүүлэх ажиллагаанд хамаарах үндсэн асуудлуудаас гадна талууд гэмт этгээд шилжүүлэх ажиллагаанд ашигласан аливаа мэдээ мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг хадгалах, хамгаалах, түүнчлэн хүний хувийн мэдээллийг өөр бусад зорилгоор ашиглахгүй байх, эрх бүхий байгууллагууд тэдгээр мэдээллийг дотоодын хууль тогтоомжийн дагуу хадгалж, хамгаалахтай холбогдох зохицуулалтыг гэрээний төсөлд тусгаад байна.

Мөн төгсгөлийн заалтуудад харилцах хэл, гэрээг хэрэгжүүлэх, хэрэглэхтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд түүнийг шийдвэрлэх арга зам, гэрээ хүчин төгөлдөр болох, нэмэлт өөрчлөлт оруулах, дуусгавар болгохтой холбоотой харилцааг тусгалаа.

Уг гэрээг байгуулснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон гэмт хэргийг таслан зогсоох чиглэлээрх талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхийн зэрэгцээ талуудын нутаг дэвсгэрт хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, бусдын эд хөрөнгөд хохирол учруулах, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, түүнчлэн мөнгө угаах, терроризм, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эсрэг зэрэг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг олж тогтоох, шилжүүлэн өгөх, улмаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх чиглэлд хоёр улсын эрх бүхий, мэргэжлийн байгууллагууд өөр хоорондоо шууд харилцаж, түргэн шуурхай хамтран ажиллах боломжтой болох юм.

Сүүлийн 3 жилийн хугацаанд манай улсын нийт **3037 иргэн** (2022 онд 2018 иргэн, 2023 онд 858 иргэн, 2024 онд 161 иргэн) Бүгд Найрамдах Киргиз Улсад зорчсон бол Бүгд Найрамдах Киргиз Улсын нийт **4362 иргэн** (2022 онд 808 иргэн, 2023 онд 1582 иргэн, 2024 онд 1972 иргэн) манай улсад зорчжээ.

Бүгд Найрамдах Киргиз Улсад улсын хилийг хууль бусаар нэвтэрсэн хэргээр хорих ял эдэлж байгаа 1 иргэн, Интерполын шугамаар эрэн сурвалжлагдаж байгаад саатуулагдсан 1 иргэн тус тус байгаагаас гадна хоёр улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд өнгөрсөн хугацаанд Интерполын шугамаар эрэн сурвалжлагдаж байсан Киргиз Улсын 1 иргэн (2024 он)-ийг манай улс шилжүүлэн өгсөн бол Киргиз Улс манай улсын 2 иргэн (2024, 2025 он)-ийг тус тус шилжүүлэн өгсөн гэсэн статистик мэдээлэл байна.

“Гэмт этгээд шилжүүлэх тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Киргиз Улс хоорондын гэрээ” нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад “Улсын Их Хурал эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээг заавал соёрхон батална” гэж заасны дагуу соёрхон батлах олон улсын гэрээнд хамаарч байх тул Олон улсын гэрээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу уг гэрээг байгуулах асуудал, гэрээнд гарын үсэг зурах эрх олгох тухай шийдвэрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой урьдчилан зөвшилцөнө.

---oOo---